

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1032

танай _____ -ны № _____ -т

Г Хандивын тайлангийн дүгнэлт Г

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Ардчилсан нам нь Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.13-т заасан хугацаанд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.7, 38.8-д заасны дагуу Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, заавар”-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Төрийн аудитын дээд байгууллага нь Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1-д заасны дагуу УИХ-ын ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Нам, эвслээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын дээд байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын дээд байгууллага УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Төрийн Аудитын стандарт MNS 6817:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан зааврыг баримтлан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай” хуулийн 56 дугаар зүйл, Улс төрийн намын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь заалтад тус тус нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

АРДЧИЛСАН НАМ нь 2024 оны ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хандив хүлээн аваагүй байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

